



Иргэний Хөдөлгөөний Нам"-ын мөрийн хөтөлбөр  
2012 оны 05-р сарын 09

**ИХ Намын УИХ-ын 2012 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр**

- **Иргэний давуу эрх**
- **Эдийн засгийн эрх чөлөө**
- **Эзэнтэй нутгийн төлөө**

ИХ Нам нь монгол дахь иргэний байгууллагууд, хөдөлгөөн, улс төрийн намуудын үзэл санаа, тэмцлийн туршлагыг судалж, монголын нөхцөл байдалд шинжилгээ, дүгнэлт хийсэн олон улсын байгууллага, гадаад, дотоодын эрдэмтдийн оюун сэтгэлгээний ололтод тулгуурлан төр, нийгэм эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрөө боловсруулж ард иргэддээ толилуулж байна.

Бидний хөтөлбөр бол зөвхөн нэг удаагийн сонгуульд зориулагдаагүй бөгөөд Монгол эх орноо аврах, сэргээн хөгжүүлэх, хүчирхэгжүүлэх гэсэн шинжлэх ухааны үндэслэлтэй урт хугацааны стратеги төлөвлөгөө юм.

Энэ удаагийн УИХ-ын сонгууль нь нийтлэг эрх ашгийг бүхнээс дээдлэн үзэж, одоо болон ирээдүй үеийнхээ чанартай, баталгаатай, айх аюулгүй байдлыг бүтээн бий болгох өнөөгийн **Монголын нийгмийн хямралыг гэтлэн давах их үйлсийн эхлэл** болно гэж бид үзэж байна. Энэхүү түүхэн сорилт нь Монгол улсад нутгийн өөрөө удирдах ёс, иргэншсэн нийгмийг бодит утгаар нь хэрэгжүүлж, ардчилалыг тогтоох стратегийн зорилгоор тодорхойлогдоно.

Ардчилал, шударга ёс, тэгш эрх, байдлыг хүний эрхэд суурьлан хэрэгжүүлэх хууль эрхзүй, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа, арга хэмжээг улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд авч хэрэгжүүлсэнээр бүх шатанд бугшсан авилга хэл хахууль, эмх замбараагүй байдлыг халан өөрчлөх явдал бидний улс төрийн үндсэн бөгөөд гол зорилго мөн.

Үндсэн хууль болон улс төрийн намууд, сонгууль, төрийн удирдлага, санхүүжилт, төрийн албаны зэрэг төрийн тогтолцоог бүрдүүлэгч гол хуулиудыг өөрчилж, ард нийтийн өргөн хэлэлцүүлгийн үндсэн дээр улс төрийн цоо шинэ, шударга, парламентын тогтолцоог бий болгоно.

### **Бидний зорилго**

Монгол улс нутгийн өөрөө удирдах ёсыг нутагшуулж бүс нутгийн худалдаа интегралчлалд оролцон эдийн засаг, банк санхүүгийн шинэчлэлийг хийж тээвэрлэгч дамжуулагч үндэстэн болох нь тэргүүлэх зорилт болно.

Монголын нийгэм гүнзгий хямралын улмаас гаж, замбараагүйтлийн төлөв байдалд орсон гэж бид үзэж байна. Нийгмийн ийм төлөв байдлаас бид зөвхөн зоригтой, эрс шийдэмгий өөрчлөлт хийж байж гарч чадна.

Монголын төр нь өндөр настан, олон хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу зүдүү зэрэг нийгмийн эмзэг бүлгүүдээ хайрлан хамгаалж, энэрэнгүйн гараа харамгүй сунгах ёстой. Төр нь насанд хүрсэн, боловсрол эзэмшсэн, бие эрүүл, хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг зүгээр тэжээх бус тэднийг ажлын байр, мэргэжил, орон байртай болгож, амьдралын шударга тэнцүү гарааны нөхцлийг бүрдүүлэх

ҮҮРЭГ ХҮЛЭЭНЭ

**Төрийн хатуу, зөвлөн хоёр талыг зохистой хослуулах** нь Монгол Улсын төрийн бодлогын гол зарчим байх ёстой.

Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд зөвхөн эдийн засаг, улс төр төдийгүй үзэл санаа, ёс суртахуун, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, спорт, эрүүл мэнд, гэр бүл, аюулгүй байдал, экологи зэрэг нийгэм бүрдүүлэгч үндсэн хүчин зүйлүүдийг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай. Иргэдээ гэмт хэргээс хамгаалж, амьдралын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх нь монгол төрийн эн тэргүүний зорилт мөн.

## Бидний уриа

ИХ Нам УИХ-ын 2012 оны сонгуульд “ЭМЭГТЭЙЧҮҮД ЧАДИА” уриатайгаар орж байна. Эрүүл төр, эрүүл нийгэм, эрүүл байгалийн төлөө тэмцэлд иргэн таны оролцоо хэрэгтэй. Төрийн тогтолцооны гажуудал, нийгмийн бохирдол, агаарын бохирдол, байгалийн бохирдлыг засч цэгцлэх цаг ирлээ. Энэ бол 22 жилийн өмнө Монголд эхэлсэн улс төрийн ардчиллыг улам гүнзгийрүүлж, өнөөгийн улс төр, нийгэм, экологийн гүн хямралыг гэтлэн давж, улс орондоо нутгийн өөрийн удирдах ёсыг бодит утгаар нь хэрэгжүүлж иргэний ардчиллыг тогтоох нь нийгмийн хөгжлийн түүхэн захиалга болоод байна.

ИХ Намын сонгуулийн мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр Монголын төрийн тогтолцоо эрүүлжиж, ард иргэдийн амьдрал дээшилж, амьдрах орчин сайжирч, байгаль дэлхий экологийн сүйрлийн аюулаас холдох болно гэдэгт бид гүнээ итгэж байна.

## 1. Иргэний давуу эрх

Төр засгийн үүсмэл эрхийг хуульд заасан хэмжээнд нь тогтоож иргэний заяагдмал эрх, хуулиар хориглоогүй бүх эрх чөлөөг эдлэх нөхцлөөр хангана.

### Иргэний засаглал

- Эрх баригч намуудын удирдлагын барьцаанд орсон өнөөгийн гажуудсан тогтолцоог халж иргэдээ дээдэлсэн иргэд нь засагласан иргэний ардчилсан нийгмийн харилцаанд нийцсэн парламентат ёсны тогтолцоог бүрдүүлнэ. Үүнд:
  - улстөрийн намуудаас ангид сонгогчдоо бүрэн эрхтэй төлөөлж ард түмний засаглалын зарчмыг хангаж ажиллах үүрэг, эрх мэдэлтэй төлөөлөгчдийн танхим бүхий байнгын ажиллагаатай парламентыг сонгодог утгаар нь бүрдүүлэх
  - парламентаас гаргасан хууль шийдвэрүүдийг өөрт зөвшөөрөгдсөнөөр хараат бусаар шуурхай хэрэгжүүлж ард түмэндээ шууд үйлчилдэг хүчтэй засгийн газартай байх
  - хараат бус шүүх эрх мэдлийг бэхжүүлж хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг тууштай баримтлан хэрэгжүүлэх
- Үндсэн хууль болон улс төрийн намууд; сонгууль; төрийн удирдлага, санхүүжилт; төрийн албаны зэрэг төрийн тогтолцоог бүрдүүлэгч гол хуулиудыг өөрчилж ард нийтийн өргөн хэлэлцүүлгийн үндсэн дээр улс төрийн цоо шинэ, шударга, иргэний тогтолцоог бий болгоно.
- УИХ, Засгийн газрыг эрх баригч намын улс төрийн зөвлөлөөс удирддаг хуучин арга барилыг таслан зогсооно.

- Улс төрийн намуудын хатуу гишүүнчлэлийг халж, санхүүжилтийг ил тод болгоно.
- УИХ-ын гишүүн, Иргэдийн хурлын төлөөлөгч зэрэг сонгуульт албан тушаалтныг эргүүлэн татах тогтолцоог бүрдүүлнэ.
- Төрийн үйлчилгээний хатуу журам, стандарт тогтоож иргэндээ үйлчлэгч байх гол зарчмыг хэрэгжүүлэн цагдаагийн байгууллагыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах үйлчилгээний байгууллага болгоно.
- Төрийн үйлчилгээг иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн шилжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, хөнгөн шуурхай болгох зорилгоор төрийн үйлчилгээг Интернетээр авах нөхцлийг бүрэн бүрдүүлнэ.

#### *Соёл боловсрол*

- Боловсролын салбарт эрс шинэчлэл хийж, хүн бүрийг мэргэжилтэй, өрсөлдөн амьдрах чадвартай болгох төрийн бодлого хэрэгжүүлнэ.
- Багш нарыг чадваржуулах, мэдлэг, шинэ технологи түгээх, үйлдвэрлэх, ашиглахыг дэмжсэн инновацын тогтолцоог төлөвшүүлж их дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны туршилт сорилтын баазыг тэргүүлэгч банк болон компаниудын ивээл дор хүчин, чадварыг нь дээшлүүлнэ.
- Монголчуудын гарал үүсэл, түүхийн талаар баталгаатай бус эх сурвалжаар бусдын зохиосон түүхийг өөрийн орны археологи түүхийн судалгаанд үндэслэн засварлах эрдэмтэн судлаачдын зөвлөлийг байгуулна.
- Нүүдэлчдийн их хаадын археологийн судалгааны их нээлтийг түшиглэн түүхийн аялал жуулчлалын бизнесийг шинэ шатанд гаргах нөхцлийг бүрдүүлнэ.

#### *Хүний хөгжил*

- Хүн амын өсөлт, гэр бүлийг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлж хүүхэд бүрт нийгмийн хараа хяналтыг хүргэнэ. Хойч үеийнхнийхээ өмнө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.
- Архины зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “хатуу” хууль тогтоох, экспортын чиглэлтэй / бүтээгдэхүүнийхээ 2/3-аас доошгүйг экспортонд гаргадаг/ сайн чанарын архины үйлдвэрээс бусад бүхий л төрлийн архи дарсны үйлдвэрүүдийг хаах. Шинээр архины үйлдвэр байгуулахыг зогсооно.
- Нийгмийн халамжийн хавтгайрсан бодлогыг хязгаарлан халамжийн үйлчилгээг зайлшгүй шаардлагатай бүлэгт үзүүлэх, асрамжийн газруудыг бүсчлэн болон аймаг нийслэлд байгуулан, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх төлбөрт үйлчилгээний хэлбэрийг нэвтрүүлнэ.
- Тэтгэвэр эрүүл мэндийн даатгалын сангуудыг төрийн сангаас тусгаарлан бие даалган, үйлчилгээний стандарт тогтоон олон нийтийн хяналтын систем тогтооно.
- Хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцдог тогтолцоонд шилжинэ.
- Чөлөөт зах зээлийн эдийн засгаар хөгжиж буй нийгэмд ядуу айл өрхийг хамтран аж ахуй эрхлэх боломжоор ханган хөдөлмөр эрхлэн амьдрах арга барилд сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

#### *Орон сууц*

- Нийслэл хот суурингийн утаа гамшгийн хэмжээнд хүрч оршин суугчдын эрүүл мэндэд шууд нөлөөлөх болсон тул гэр хорооллын айл өрх бүр халаалтын зориулалтаар ашиглаж буй цахилгаан хэрэгслэлийн технологийг сайжруулж хэмнэлт гаргана.

- Орон сууцаар хангаж хөтөлбөрүүдийг эрчимжүүлнэ.

**Иргэний мэдэх эрх**

- Мэдээллийн эрх чөлөөг хүний эрхийн гүгээмэл тунхагт нийцүүлэн аливаа мэдээллийг хүчирхийллийн бус аргаар хайх, олж авах, түгээх эрх чөлөөг баталгаажуулан мэдээллийг иргэдэд ил тод болгоно.
- Гэмт үйлдлийн шинжтэй мэдээллийг төрийн нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож, олон нийтэд худал болон зөрчилтэй мэдээлэл өгсөн, мэдээллийг нуун дарагдуулсан, хоцроосон албан тушаалтайд хариуцлага хүлээлгэдэг болно.
- Радио, телевиз, хэвлэл мэдээллийг улс төрийн бүлэглэл, олигархиудын хяналтаас бүрэн гаргаж, хүчирхийлэл, садар самуун, гаж үйлдэл зэргийг өдөөгч мэдээллийн терроризмыг таслан зогсооно.

*Сонгууль, санал асуулга*

- Ардчилсан нийгэмд улс төрийн намуудын өрсөлдөөний гол талбар нь сонгууль байдаг нөхцлийг хангасан боловсронгуй сонгуулийн хуулийг хэлэлцэн батлуулах
- Ард нийтийн санал асуулгын тогтолцоог боловсронгуй болгож нийгмийн бүлгүүдийн санал асуулгын сүлжээг хөгжүүлнэ.

**2. Эдийн засгийн эрх чөлөө**

- Өнөөдөр монгол улс нефть бүтээгдэхүүн 100 хувь аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, хүнс ба өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ 90 хувийг гадаадаас импортоор авч хэрэглэдэг түүхий эдийн хавсарга улс болгосон гажуудал нь хэзээ ч ажлын байрны тоо олшрохгүй, ашиг орлого нэмэгдэхгүй, ядуурал буурахгүй болсоныг засан өөрчлөх зорилтыг хэрэгжүүлнэ
- ИХ Нам Монгол улсыг тээвэрлэгч, дамжуулагч болгох зорилтыг 1-рт тавьж, бүс нутгийн худалдаа, интегралчлалд оролцон орос хятад улсыг холбосон эрчим хүч дамжуулах өндөр хүчдэлийн шугам, газрын тос байгалийн хий дамжуулах хоолойн ажлыг эхлүүлж цахилгаан дамжуулах шугамыг ашиглалтанд оруулж ахуйн хэрэглээний цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Төрийн уламжлалт залгамж бодлогыг дэмжиж Азийн хөндлөн хурдны авто зам, төмөр зам, Ази Европ, Хойд Америкийн агаарын тээврийн зангилаа болох Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал зэрэг өмнөх парламентийн хугацаанд биелэгдээгүй ажлуудыг дуусгана.

*Банк санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл*

- Экспортод чиглэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс тусгайлан дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлж чөлөөт зах зээлийн амин сүнс болсон эдийн засгийн хүчин чадлаа нэмэгдүүлэх бодлого баримтална.
- Ашигт малтмал олзворлогч компани аж ахуйн нэгж, хувь хүмүүс ашиг орлогоо гадаадын банкинд байршуулахыг хориглон банкууд хадгаламжийн хүүгээрээ уралддаг тогтолцоог таслан зогсоож харилцагчийнхаа мөнгийг хадгалж нэмэлт үйлчилгээ үзүүлсэнийхээ төлөө шимтгэл авдаг дэлхий нийтийн жишгийг нэвтрүүлж хямд санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

- Иргэдээ банкны хүүгийн боолчлолоос чөлөөлж монголын газар нутаг дээр банкууд мөнгө хүүлэх ажил эрхлэхийг хориглон харилцагчиддаа үзүүлсэн үйлчилгээнээсээ л ашиг олдог зарчмыг хэрэгжүүлнэ.
- Бизнес эрхлэгчдийн авсан зээлийн хүү жилийн 3-5 хувь байхад үйлдвэрлэл аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа сэргэдэг зах зээлийн үндсэн хөрсийг бий болгоно.
- Хөдөө аж ахуйг шинэчлэн сэргээн байгуулж, өрсөлдөх чадвартай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тэргүүлэн хөгжүүлнэ. Үндэсний үйлдвэр, хөдөө аж ахуйг хамгаалан хувийн аж ахуйг дэмжин, ажлын байрыг шинээр бий болгон ядуурлыг бууруулах, урамшуулах тууштай хатуу бодлого баримтлан жилийн 2-3 хувийн хүүтэй банкны зээлийн үйл ажиллагааг нэвтрүүлнэ.
- Банкны хамгийн том зардал болох төрийн мөнгө байршуулсаны төлөө төлдөг авилгал, хууль бус зардлуудыг таслан зогсооно.
- Ажилчид, малчидын цалин болон малаа барьцаалсан зээл, орон сууцны зээл, хүүгийн дарамтаас чөлөөлөх бодлогыг банкуудад эрсдэл учруулахгүйгээр хамтран ажиллаж иргэддээ эдийн засгийн эрх чөлөө олгох бодлогыг баримтална.
- Аж ахуй дахь төрийн хэт оролцоог хязгаарлаж, бизнест дарамт учруулж буй хууль тогтоомж, журмыг өөрчлөн шинэчлэх шийдвэртэй арга хэмжээ авна. Бизнесийн лиценз олголт, мэргэжлийн хяналтын үүргийг бизнесийн өөрөө удирдах зарчмаар ажиллах салбарын холбоодод шилжүүлнэ.

### 3. Эзэнтэй нутаг

#### *Нутгийн өөрөө удирдах ёс*

- Улс орны засаг захиргааны хуваарьт өөрчлөлт оруулан нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт шилжүүлэн төр, түүний бүтцээс ангид нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчид нутаг орондоо жинхэнэ ёсоор эзэн байж амьдрал ахуйнхаа өөрсдөөс хамаарах асуудлуудыг бүрэн бие даан шийдвэрлэх боломж бүхий нутгийн өөрийн удирдлагыг олон улсын жишиг эрх зүйд нийцүүлэн байгуулж төлөвшүүлнэ.
- Нутгийн өөрөө удирдлагын бие даасан хөгжлийг дэмжиж төр засгаас дотоод асуудалд нь оролцдог хуучин арга барилыг нь өөрчилнө.
- ИТХ-ын эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлж, орон нутгийн татварын бие даасан тогтолцоог бий болгоно.
- Улсын төсвөөс сум, дүүргүүдэд хувиарлагдаж байгаа мөнгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ УИХ-ын гишүүдэд зарцуулах эрхтэйгээр хувиарлаж байгаа 76 тэрбум төгрөгийг жил бүр сум дүүргүүдийн мэдэлд олгож байх
- Газар нутаг болон түүний баялгийг ашиглахтай холбогдсон зөвшөөрлийг түүнд хамрагдах нутаг дэвсгэрийн нэгжүүдийн оршин суугчдын 2/3-аас доошгүйн зөвшөөрөөлгүйгээр эзэмшүүлж ашиглуулахыг хориглоно.

#### *Байгаль орчин, экологи*

- Эх орон, газар шороо, иргэдийн эрх, эрх чөлөөний төлөө ажиллаж тэмцэж байгаа улс төрийн нам хүчнүүд, иргэний байгууллагууд иргэдтэй хамтран ажиллах зарчмыг тууштай баримтлана.
- Экологийн глобал өөрчлөлтүүдийг тооцон, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, өнөөгийн экологийн сүйрлийг хязгаарлана. Нутаг усыг сүйтгэсэн, хордуулсан

хохирлын цар хэмжээг тогтоож, улмаар нөхөн сэргээх, хор уршгийг арилгуулах эрс шийдэмгий арга хэмжээ авна.

- Уул уурхайд болон үйлдвэрлэлийн хэрэглээнд гүний цэвэр усны ашиглалтанд хязгаарлалт онцгой тариф мөрдөнө.
- Байгалийн баялгийн үнэлгээ, ашиглалтын өнөөгийн тогтолцоог бүрэн өөрчилж, экологийн урамшуулал, татвар, торгууль, стандартын шинэ тогтолцоог бий болгоно. Экологийн цагдаагийн албыг байгуулна.
- Өмнөх парламент, Засгийн газрын үед хэрэгжүүлж чадаагүй "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль"-ийг хэрэгжүүлнэ.

*Уул уурхай, ашигт малтмал*

- Уул уурхайн олзворлолт, эрдэс баялгийн салбарт дахин шинэчлэлт, хувиарлалт хийж иргэдийн мэдэлд, хуулийн хамгаалалтанд авна.
- Ашигт малтмал эрдэс баялгийн төв бирж байгуулж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийг дэлхийн зах зээлийн үнээр экспортлох бодлого баримтлана.
- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ. Эцсийн бүтээгдэхүүний болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж бүс нутаг дахь эдийн засгийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Хууль бусаар олгогдсон лицензийг хурааж, лицензийн наймааг бүрэн хална.
- Уурхайн олзворлолтын дараах хонхор, нүх, эвдрэлийг засч хиймэл нуур цөөрөм байгуулах, усны нөөц сайтай гол мөрний усыг татах далангийн ажлыг эхлүүлнэ. Төр, нийгэм, байгаль дэлхийгээ эрүүл, цэвэр байлгаж, төр засаг, нутаг орон, өрх гэрийнхээ жинхэнэ эзэд болж явах нь монголчууд бидний Монголдоо сайхан амьдрах гол зарчим билээ.

Эрүүл төр, эрүүл амьдрал, эрүүл нутгийнхаа төлөө хамтдаа зүтгэе. Алдаагаа засч бодит өөрчлөлт хийцгээе.

**ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ**

